


БАТЛАВ:



НИЙЛҮҮЛЭГЧ:

"ПРОЛИАНС" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Л.БАЯРМАА

XIX.3.29 УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ /УЛААНБААТАР, СҮХБААТАР ДҮҮРЭГ, БАГЦ-3/ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 162

Улаанбаатар хот

Нэг талаас "Эрүүл мэндийн яам" (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас "Пролианс" ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Төрийн худалдан авах ажиллагааны газрын 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А-1/952 тоот "Зөвлөмж хүргүүлэх тухай" албан бичгийг үндэслэн XIX.3.29 Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, Багц-3/ нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрч гэрээ байгуулав. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг 1,202,500,000.0 (Нэг тэрбум хоёр зуун хоёр сая таван зуун мянган) төгрөгөөр Улсын төсвөөс санхүүжүүлж тоног төхөөрөмжийн хүлээлгэн өгснөөс хойш 30 хоногийн дотор нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн барааг, талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажсанаас хойш 60 хоногийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

№	Барааны нэр	Барааны гарал үүсэл	Марк	Тоо ширхэг
	1	2	3	4
1	Integra CUSA Excel аппаратны гар	АНУ	C2600	2
2	Хэвллийн дурангийн мэс засал хийх аппарат иж бүрдэл /2 цамхаг , 5 иж бүрдэл багаж /	ХБНГУ	KARL STORZ	2, /5/
3	Мэс заслын дурангийн HD систем / оптик/ Hopkins telescope /flu orescence-supported perfusion evaluation using ICG-2	ХБНГУ	ICG/INR telescope	2
4	Hopkins telescope /энгийн/ 5,10мм	ХБНГУ	Hopkins telescope	4

5. Захиалагч болон нийлүүлэгч байгууллагын зүгээс үл хамаарсан хүчин зүйлсийн улмаас гэрээний зарим зүйл заалт биелүүлэх хугацаа хойшлогдсон тохиолдолд хоёр тал харилцан тохиролцож, зөвшилцөн шийдвэрлэнэ.

6. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Үнийн хуваарь;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь;
Гүйцэтгэлийн баталгаа;
Баталгаат хугацааны мэдэгдэл /албан тоот/
Гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн тухай мэдэгдэл /албан тоот/

7. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

8. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

9. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын дарга

Д.Нарантуяа Д.Нарантуяа

Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Т.Хонгорзул

Хуулийн хэлтсийн гэрээний мэргэжилтэн

Д.Туяа

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭТТАлбаны захирал:

Х.Армия

Борлуулалтын менежер

Ш.Цэнгэл

Хөрөнгө оруулалтын хэлтсийн
ахлах мэргэжилтэн

Г.Бат-Эрдэнэ



Хаяг: Эрүүл мэндийн яам, Засгийн
газрын VIII байр, 1 давхар 106 тоот
өрөө Улаанбаатар-48, Олимпын
гудамж-2

Утас: 51-263631, Факс: 323541

Хаяг: "Пролианс" ХХК, Улаанбаатар
хот 14210, Сүхбаатар Дүүрэг, 1-р
хороо, олимпын гудамж 15/2,
Мидтаун оффис, #402

И-мэйл: medical@proliance.mn

Утас: 75078000

Дансны дугаар: 5000020842

ХАС банк